



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 768

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас  
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.3.4, 6.4.2, 6.4.3 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Автотээврийн үндэсний төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын Баянхонгор аймгийн Автотээврийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 13,000,000.00 (арван гурван сая) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг данснаас хасч, сэлбэгийн зориулалтаар "Хархорин-А33А"-д хүлээлгэн өгөхийг зөвшөөрсүгэй.

2. "Автотээврийн үндэсний төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Н.Гүрсоронзонд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулах;

2.2. Хавсралтад заасан хөрөнгийг эргэлтийн хөрөнгөөр ашиглах, бүртгэх ажлыг зохион байгуулах;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Акталж данснаас хассан тээврийн хэрэгслийг улсын бүртгэл болон татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс /Д.Нарангэрэл/-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Д.Нарангэрэл

Д.НАРАНГЭРЭЛ

13201701

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын  
газрын 2020 оны 12 дугаар сарын 28-ны  
өдрийн 768 дугаар тогтоолын хавсралт

**"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын харьяа Баянхонгор  
аймгийн Автотээврийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй  
хөрөнгийг сэлбэгийн зориулалтаар "Хархорин-АЗЗА" ТӨХК-д  
шилжүүлэх үндсэн хөрөнгийн жагсаалт**

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглал танд орсон огноо	Балансын, хуримтлагдсан элэгдлийн дүн (төгрөг)
1	Ниссан маркийн, 00-77 БНХ улсын дугаартай, суудлын автомашин, арлын дугаар- NT30028294	2001/2010	13,000,000.00
	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		13,000,000.00 (арван гурван сая)